

Тод үсгийн цагаан толгойтой холбогдох дурсгал бичгүүд хийгээд ойрдын хэлшинжлэлийн уламжлал

Гүн нарийн шинжлэх ухааны үндэс суурь бүхий биеэ даасан үсэг бичгийн хувьд дэлхийн боловсорсон үсэг бичгүүдийн дотор өөрийн онц байр сууриа эзэлж байгаа тод үсэг 1648 онд зохиогдсон тэр цагаасаа эхлээд тухайн үеийн Дөрвөн ойрдын төр шашины хамаг хэрэгт идэвхтэй хэрэглэгдэж агсан бөгөөд, тод үсгийн зохиогч нь энэ бичгээ зөвхөн тэр үеийн Дөрвөн ойрдод л төдий биш мөн тухайн үеийн нийт монгол хэлтэнүүдэд зориулж зохиосон гэдгийг эрдэмтэд нэгэ биш удаа батласан билээ¹.

Тод үсэг дээр бичигдэж үлдсэн дурсгал бичгийн зүйл манай энэ үед дамжиж ирсэн нь тоогоор чамалж болошгүй олон байгаа дээр төрөл зүйлээр ч олон буй бөгөөд өдгөө дэлхийн олон орнуудад, ялангуяа Монгол, Орос, Хятад зэрэг орнуудад хадгалагдаж байгааг бид мэдэж бий. Тэр олон зүйлийн дурсгал бичгүүдийг их төлөв шашны гүн ухаан, зурхай, анагаах ухаан, түүх, сургаал, сан тахилгын гэх мэт олон зүйлд ангилан үзэж болох бөгөөд тоогоор хамгийн цөөхөн боловч агуулгын талаар маш чухал нэгэ төрлийн дурсгал бичиг байгаа нь даруй үсэг бичигтэй холбогдох зүйл мөн.

Тод үсгийн цагаан толгойтой холбогдох дурсгал бичгийн зүйл нь судар хэлбэрийн гар бичмэлээр өргөн хэрэглэгдэж агсан ажээ. "Тод үсгийн дэлгэр цагаан толгой" хэмээх дурсгалын зүйл урьд нь байсан тухай мэдээг Монгол улсын эрдэмтэн М. Амгалан XX зууны жараад онд олсон² бөгөөд өнгөрсөн зууны гуч, дөчөөд он хүртэл "Шүтэн сурах гучин цагаан үсэг" буюу "Тод монголын гучин цагаан үсэг" хэмээх зүйл байсан ба ийм сурах бичгээр тэр үед тод үсэг сурч байсан тухайгаа Хятадын Шинжааны Ховогсайр нутагтай миний эцэг Дүүрэнгийн Намжав надад 1996 онд ярьсан билээ. Миний эцгийн хэлснээр бол тэр үед тод үсгийг ер нь эрт дээр үед хэвшиж тогтсон монгол бичиг заадаг уламжлалаар сургаж байсан ажээ. Жишээлбэл, үсэг бүгдийг тэдгээрийн гадар дүрс байдлаар нь буюу үсгүүдийг бүрэлдүүлж байгаа үндсэн махбодоор нь ялган нэрлэж цээжлүүлдэг агсан бөгөөд унших бичгийн зүйлд "Итгэл", "Дарь эх", "Базардара", "Тарбучэмбо"

мэт судрын зүйлүүдийг хэрэглэж байсан ажээ. Харамсалтай нь тэдгээр үнэт дурсгалын зүйлс жараад онд Хятадын "соёлын хувьсгалын" их шуурганд сүйдэж үрэгдсэн ажээ.

Харин XX зууны хоёрдугаар хагаст эрдэмтэдийн хүчин чармайлгаар тод үсгийн цагаан толгойтой холбогдох цөөхөн тооны дурсгалын зүйлс олдсон нь тод үсэг хийгээд монгол ойрдын хэлшинжлэлийн уламжлалыг судлах үнэт хэрэглэгдэхүүн болж буйг энд ширхэгчлэн заахад: тод үсгийн цагаан толгойн талаар одоогоор олдсон хамгийн дэлгэрэнгүй агуулга бүхий, эрдэмтдийн сайн мэддэг "Үзгийн найрлага", тод үсгийн цагаан толгой, түүнийг заах арга зүйн талаар сонирхолтой мэдээ бүхий "Тод монгол үсэг хэмээх оршив", Заяа бандидын өөрөө орчуулсан, энэтхэгийн тавин үсэг, түвдийн гучин үсгийг тод үсгээр хэрхэн галиглах ёс хийгээд авиан зүйн зарим зарчмийн тухай тайлбар сэлтийг агуулсан "Олон номын үндсэн үзгийн ялгал" ба "Тарни унших арга хураасан хэмээх оршив" нэртэй судруудыг зааж болно. Эдгээр ховор үнэт дурсгалын зүйлс нь олдсон тэр өдрөөсөө монголч эрдэмтэдийн анхаарал сонирхолыг ихэд татаж, эрдэмтэдээс эдгээр судар бичгүүдийн ерөнхий агуулга хийгээд эх бичгийн судлал, гэрэл зурагийн хуулбар тэргүүтнийг удаа дараагаар нийтлүүлж, эрдэм шинжилгээний хүртээл болгосныг өнөөдөр бид гарын авлага болгон ашиглаж бий.

"Үзгийн найрлага", "Тод монгол үсэг хэмээх оршив" эн хоёр цагаан толгойн бичгийг хамгийн анх монголын нэрт эрдэмтэн агсан Х.Лувсанбалдан гуай бээр 1972 онд Унгарийн "Дорно дахины судлалын мэдээ" сэтгүүлийн XXV ботьд латин үсгийн галиглал, холбогдол бүхий тайлбар сэлтийг Франц хэлээр нийтлүүлэхдээ "Үсгийн найрлага" -ыг харин "Үсгийн гарлага" нэрээр нийтлүүлсэн нь сонирхолтой ажээ³. Энэхүү "Үсгийн найрлага"-ын бас нэг хувилбар Монголын эрдэмтэн Г. Жамъянгийн хувийн цуглуулгад хадгалагдаж агсаныг эрдэмтэн Ц. Баярсүрэн латин галигаар бүрэн галиглаж нийтлүүлснийг бид мэднэ⁴.

"Олон номын үндсэн үзгийн ялгал" хэмээх судрын төгсгөлийн үгэнд "онц сайн үйл хурааснаар олны эзэн цол олон, ономгой ухаанаар онц дээд кэрлэгч Аюш дурдсанд Огторгуйн Далай Раб жам Заяа бандид орчуулав" гэж бичээтэй байгаа боловч академич Б. Ринчэн гуай харин Заяа бандид зохиосон хэмээн тэмдэглэсэн бөгөөд тэрээр оршил бичсэн "Сарны гэрэл"-ийн монгол эхийн хойно эн судрын гэрэлзургыг

дагалдуулан нийтлүүлэхдээ хуудасны дараалалыг нь хутгалдуулсан ажээ⁵.

"Тарни унших арга хураасан хэмээх оршив" судар Орсын Шинжлэх Ухааны Академийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн Санкт Петербург дахь салбар хүрээлэнгийн номын санд хадгалагдаж байгаа бөгөөд түүний гэрэл зурагийн буулгабар нь Монголын Шинжлэх Ухааны Академийн хэл зохиолын хүрээлэнгийн тод номын хөмрөгд хадгалагдаж бий.

"Үзгийн найрлага" хэмээх судрын хоёр хувилбар нь зарим үг өгүүлбэрийн яламгүй ялгааг гаргабал агуулгын талаар бүрэн тохиролцдог бөгөөд юуны өмнө эртний хэлшинжлэлийн дурсгал бичгүүдэд нийтлэг байдаг "тахил өгүүлэл" хэмээн нэрлэгддэг залбаралын зүйлээр эхэлж, энэтхэгийн тавин үсэг, түвдийн гучин үсгийг тод үсгээр галиглах ёс, дараа нь тод үсгийн үндсэн цагаан толгой буюу эгшиг долоо, эгшигээр амилсан 16 гийгүүлэгч үсэг, дараа нь 13 дэвсгэр үсгийг багтаасны дээр тод үсгийг зохион үйлдэх сануулга дурдсан хүмүүс, зохиох болсны шалтгаан, зохиосон хүн тэргүүтнийг товч тодорхой өгүүлсэн төгсгөлийн үгтэй. Энэ тодорхой тэмдэглэл нь тод үсгийн судлалд сонирхолтой мэдээ хангаж өгсөн билээ.

"Олон номын үндсэн үзгийн ялгал" хэмээх судар нь "Тарни унших арга хураасан хэмээх оршив" нэртэй судар лугаа агуулгын талаар бүрэн тохиролцдог бөгөөд тахил өгүүлэл гурван мөр залбарал, дараа нь энэтхэгийн тавин үсэг буюу «тодотгон үйлдэгч 34, эгшигийн 16», түвдийн гучин үсгийг тод үсгээр галиглах ёс, дараа нь энэтхэгт үгүй түвдэд буй үсэг аль вэ? энэтхэг түвд хоюуланд нь буй, өгүүлэх ёсон адил бус үсэг аль вэ? зузаан үсэг аль вэ? хүчтэй үсэг аль вэ? дунд үсэг аль вэ? залгих үсэг аль вэ? урт үсэг аль вэ? их үсэг аль вэ? өцүүхэн үсэг аль вэ? эр үсэг аль вэ? эм үсэг аль вэ? манин(саармаг) үсэг аль вэ? маш урт үсэг аль вэ? таван махбодын үсэг аль вэ? тэдэнд дуун гарах найман орон болох аль вэ? гэх мэтийн 15 асуулт, энэ 15 асуултын тайлбар, хамгийн эцэст орчуулахыг дурдсан хүн хийгээд орчуулсан хүнийг заасан төгсгөлийн үг зэрэг агуулгыг багтаасан байгаа юм.

Тод үсгийн цагаан толгой лугаа холбогдох эдгээр дурсгалын зүйлс нь тод үсгийн үндсэн цагаан толгой, түүний галиг үсгийн ерөнхий системийг таниж мэдэхэд үлэмж их учир холбогдолтойгоор зогсох биш мөн эртний манай өвөг дээдсийн үсэг бичгийн тухай буюу хэлшинжлэлийн бүтээл туурвиж байсан ёс, өөрийн хэл бичгийн тухай дээр үеийн ойлголт,

хэлшинжлэлийн үүднээс өөрийн хэлээ тайбарлаж байсан онолын үндэс, дээр үеийн хэлшинжлэлийн онол ба мэдлэгийн түвшин тэргүүтэн чухал асуудлуудыг судлахад үндсэн баримт болох зүйлс мөн.

Эдгээр дурсгал бичгүүдийг үсэг зүйн үүднээс шинжлэж, тэдгээрийн ерөнхий байдлийг тодорхойлсон өгүүлэл зохиол цөөнгүй байгаа боловч эдгээрт тусгагдсан дээр үеийн манай хэлшинжлэлийн уламжлалыг шинжлэсэн гэмээр зүйл харин ховор байх шиг санагдаж байна.

"Үзгийн найрлага" зэрэг тод үсгийн цагаан толгой лугаа холбогдох дурсгалуудын ерөнхий тогтолцоог авч үзэхэд энэ нь эртний үсэг бичгийн тухай буюу хэлшинжлэлийн бүтээл туурвидаг уламжлал тэр хэвээрээ мөн бөгөөд монголчуудын хамгийн анхны хэлшинжлэлийн бүтээлийн нэг нь болох, Чойжидцар хэмээх нэрт эрдэмтэн XIV зууны үед туурвисан "Зүрхэний тольт" хэмээх бүтээлийн бүтэц тогтолцоо нь ямаршуу байсныг энэ бүтээлийн ерөнхий агуулгыг тусгаж үлдээсэн, XVII зууны үеийн нэрт эрдэмтэн агсан Данжиндагваа бээр туурвисан "Огторгуйн маань" – аас⁶ үзэхэд бүх зохиол нь "алин цагтор гарсан уг хийгээд үсгийн ялгал ба махбодын ялгал" хэмээх гурван хэсгээс бүрэлдсэн байгаа бөгөөд хоёрдугаар хэсэг буюу үсгийн ялгал хэмээх хэсэг нь "тахил өгүүлэл, бодит, сүүл" хэмээх гурван зурвасаас бүрэлдсэн ажээ. Үүнд «тахил өгүүлэл» гэдэг нь эхлэл үг буюу уламжлалт залбаралын зүйл, «бодит» гэдэг нь даруй хамгийн гол агуулга, «сүүл» гэдэг нь төгсгөлийн үгийг заадаг агсан нь ил байна. "Үзгийн найрлага" бол яг "Зүрхэний тольт"-ын доторхи "үсгийн ялгал" хэмээх хэсэг лүгээ тохиролцох зүйл мөн ажээ.

Ер нь монгол хэлтнүүд "Зүрхэний тольт"-ыг зохиож байсан тэр үед нэгэнтээ өөрийн хэлээ авиан зүйн үүднээс эгшиг, гийгүүлэгч хэмээн ялгаж, эгшигээ чанга, хөндий, саармаг буюу эр, эм, эрсүү хэмээн ялгаж агсан бөгөөд гийгүүлэгч авиануудын авиалах арга, байрийг ч гэсэн маш оновчтой тогтоосон нь хожмын ижил агуулга бүхий зохиолуудад мөрдлөг болсоор ирсэн ажээ.

Авиа нийлэлдэж үг бүтээхэд авиануудын гүйцэтгэж байгаа үүрэг хийгээд авиан зүйн онцлогт нь тулгуурлаж хэлшинжлэлийн нэр томъёогоо тогтоож агсан тухай мэдээ нь дээр үеийн манай хэлшинжлэлийн онлын өндөр түвшнийг харуулж байгаа бас нэг гэрч мөн ажээ.

"Дуу аялгуу" хэмээх утга бүхий санскрит хэлний "эгшиг" гэдэг нэрээтгэлийг монгол хэлтнүүд маш дээр үед зээлдэн авч хэрэглэж агсан бөгөөд "эгшиг үсэг" буюу "эгшиг долоо" хэмээн нэрлэх болсоны учрыг тайлбарлахдаа "олон үсгийг цөм энэ долоогийн аялгуугаар даган дуудаж болхын тул эгшиг үсэг хэмээн нэрлэсэн болой"⁷ гэжээ. Энд хэлж байгаа олон үсэг гидэг нь нөгөө гийгүүлэгч үүсгээ зааж байгаа бөгөөд, хамаг гийгүүлэгч үсэгт энэ долоон эгшигээ уяж амилуулан дуудаж болноо гэсэн үг мөн ажээ ("үзгийн найрлага" -д гийгүүлэгч хийгээд эгшиг нийлэлдэж задгай үе бүтээхийг үзгийн уялга гижээ). Мөн гийгүүлэгч үсэг хэмээн нэрлэх болсоны тухай "Монгол үсгийн гол ёсоныг тодотгогч толь хэмээх бичиг"⁸ дурсгалд бичихдээ: "эднийг юуны тул гийгүүлэгч үсэг хэмээмүй хэмээбээсү нэр утга бүгдийг тодотгохын тул тийн хэмээжүхүй" гээд, гийгүүлэгч үсэг инү "эгшигийн амин төгөлдөр бус, нүдэн ирмэхийн хагасын өнийн хэмжээт, сонсогдох дууны өнгөгүй болой" гэжээ. Энэ нь гийгүүлэгч үсэг буюу авиа нь дангаараа сонсогдох дууны өнгөгүй, үгийн дотор оролцоод зөвхөн тухайн үгийн утгыг ялгамжтай болгодог л үүрэгтэй байхад, эгшиг нь харин эдгээр сонсогдох дууны өнгөгүй гийгүүлэгчдээ амь оруулж, сонсогдох дуутай болгож бий гэсэн хэрэг ажээ. Иймээс "тодруулах, гэрэлтүүлэх" гэсэн утга бүхий "гийгүүлэх" гидэг үйл үгэнд "-гчи" хэмээх нэр бүтээх нөхцөл залгаж «гийгүүлэгч» хэмээх тусгай нэр зохион хэрэглэсэн нь харин нарийн бодож тогтоосон зүйл болох ажээ. Үүнээс Заяа бандидын "тодотгон үйлдэгч 34" хэмээн энэтхэгийн гучин дөрвөн гийгүүлэгч үсгийг нэрлэсэн нь уг нэрийн үгэчилсэн орчуулга мөн болох нь тодорхой болж бий.

Үүнээс бид дараах зүйлүүдийг мэдэж болмоор байна: гийгүүлэгч авиа гэдэг маань дангаараа чихэнд сонсогдох дууны өнгөгүй, тэгээд ч ганцаараа үе буюу нийлбэр бүтээж чаддаггүй, зөвхөн эгшигийн туслалцаагаар сонсогдох дууны өнгийг олж, эгшигийн туслалцаагаар үе бүтээж чаддаг ёсыг мэдэж болох бөгөөд энэ нь бид нарийн өнөөдөр сайн мэддэг ерөнхий хэлшинжлэлийн түгээмэл онол мөн юм.

Уламжлалт үсэг зүйн судлалд гийгүүлэгч үсгүүдээ дэвсгэрлэх гийгүүлэгч ба үл дэвсгэрлэх гийгүүлэгч хэмээн хоёр ангилж, дэвсгэрлэх гийгүүлэгчээ дэвсгэр үсэг хэмээн нэрлэдэг агсаныг бид мэднээ. Дэвсгэрлэх гийгүүлэгч буюу дэвсгэр үсэг гэдэг маань одоогийн ярьдаг битүү үе бүтээдэг гийгүүлэгч үсэг мөн. Өөрөөр хэлвэл, эгшиг үе буюу гийгүүлэгч + эгшиг үеийн

хойно орж битүү үе бүтээдэг гийгүүлэгч гэсэн үг болох бөгөөд үүнийг уламжлалт хэлшинжлэлийн бичгүүдэд " амин төгөлдөр нэрийн гол үсгийн дэвсгэр дор ирвээс түүний хүчээр сонсогдох дууны өнгө олж, хэзээ ч амин төгөлдөр үсэг нэгэний нөхөр дэвсгэр дор ирхээс бус хувьдаа нэрийн гол болох чадалгүй" гэжээ. Дээр ярьсан мэт манай хэлэнд гийгүүлэгч үсэг болгон дэвсгэрлэж болдоггүй журамтай агсан үүнд б, г, р, с, д, ш (ховор тохиолдно), н, м, л, нг хэмээх арван гийгүүлэгч л дэвсгэрлэж болдог атал нөгөө х, к, г, з, ж, ц, т зэрэг гийгүүлэгч үсгүүд харин дэвсгэрлэж чаддаггүй, хэзээд хойноо эгшигийн амитай дуудагддаг онцлог нь манай төрлөх хэлний авиан зүйн ёсноос үүссэн зүйл мөн ажээ. Академич Б. Ринчэн гуайн бичиснээр дэлхийн олон хэлэнд хоёр зүйлийн ёрөнхий тогтолцоо байдаг үүнд, нэг зүйл нь үеийн эхэнд гийгүүлэгч авиа давхардуулан оруулдаггүй тогтолцоо, нөгөө нэг зүйл нь үеийн эхэнд хэд хэдэн гийгүүлэгч авиа давхардуулан оруулдаг тогтолцоо болох бөгөөд монгол хэлтнүүдийн хэл бол нэгдүгээр тогтолцоо буюу үеийн эхэнд гийгүүлэгч авиа үл давхардуулдаг тогтолцоо байж, хэрвээ славян хэлэнд «прст, смрт, крк» гэх мэт дан ганц гийгүүлэгчээр бүтсэн үг хүртэл байдаг байхад, манай хэлэнд бол ийм үзэгдэл харин ойлд оршгүй зүйл болох ажээ⁹. Харин «власть, град, брег» гэх мэтээр орчин цагийн орос хэлнээ үгийн түрүүн нийлбэрдээ давхар гийгүүлэгчтэй бичигдэж хэлэгддэг үгс нь эрт дээр үед орос хэлний зарим аялгуунд «волость, город, берег» гэх мэтчилэн эгшигтэй хэлэгддэг байсныг славян хэлний материалаар шинжлэгээний хэрэглэгдхүүнээ болгож, түүхийн харьцуулсан хэлшинжлэлийг үндэслэсэн А. Х. Востоков тэмдэглэжээ¹⁰. Энэ нь дээр заасан хоёрдугаар тогтолцоонд багтдаг славян хэлэнд ч нэгдүгээр тогтолцооны онцлог агсаныг тодорхойлж байгаа зүйл мөн.

XX зууны эхээр монгол хэлтнүүд, түүний дотор Монгол улс ба Халимаг, Буриадад өөрийн үндэсний бичгээ орхиж, кирилл үсэгт дулдуйдсан шин үсэгийг зохион, өөрийн хэлний зөвбичих дурмээ тогтоохдоо харин дээр заасан нэгдүгээр тогтолцоо буюу үеийн эхэнд ба үгийн эцэст гийгүүлэгч авиа давхардуулан оруулдаггүй тогтолцоогоо нэг хэмжээнд эвдсэн нь төрлөх хэлнийхээ авиан зүйн зарчмыг зөрчсөн хэрэг болсон бөгөөд энэхүү алдасыг манай ахмад үеийн эрдэмтэд агсан Б. Ринчэн, А. Ш. Кичиков нар заан тэмдэглэж агсан боловч эдүгээ хүртэл бид нар энэхүү алдсаа засаж авч чадаагүй байгаа маань хармсалтай бөгөөд үүний учрыг сүвэгчилвэл манай

хэлшинжлэлч эрдэмтэдийн «санаа нь байвч унаа нь хүрэхгүй» байгаагийн хэрэг биз. Ер нь академич Б. Я. Владимирцов гуай монгол бичгийн зөвбичих дүрмийг «чрезвычайно высокоразвитый язык» хэмээж, тод үсгийн зөвбичих дүрмийг «идеальная орфография» хэмээн маш өндөр үнэлсэн нь гүнзгий учир утгатай юмаа. Ямар нэгэн үсэг бичгийн системийг авч, өөрийн хэлнийхээ зөвбичих дүрмийг тогтоохдоо юуны өмнө өөрийн хэлнийхээ тогтолцоог мөрдлөг болгох нь зүйтэй бөгөөд, бид нарт бол манай үндэсний бичиг бологч монгол бичиг хийгээд тод үсгийн зөвбичих дүрэм нь бидний мөрдөн дагах толь болох ажээ. "Правильная оценка орфографических правил монгольского письменного языка дает чрезвычайно много для выяснения законов и норм самого монгольского языка"¹¹ хэмээн академич Б.Я. Владимирцовын тэмдэглэсэн нь онож хэлсэн үг болох бөгөөд энэ нь манай ойрод-халимаг хэлний уул ёс журамыг таниж мэдэхэд тод үсэг, түүний зөвбичих дүрэм нь хэмжээлэшгүй их учир холбогдолтойг заасан хэрэг мөн.

Монгол хэлтнүүдийн хэлшинжлэлийн уламжлалын тухай академич Б.Ринчэн бичихдээ: «Европ зүгт Христосын суртахууны номын хэл байсан герег, латин хоёр хэл нь сонгодог хэл болж, шашны номын хэлнээс шинжлэх ухааны хэл болж ирээд, латин хэлзүйн ёсы нь үсэгзүйч, хэлзүйчнэр боловсруулан, түүний загварыг өөр өөрийн хэлний зүйн загвар болгон ирсэнлүгээ адил, манайханд энэтхэг төвд хэл нь Европ зүгийн герег латин хэлний үүргийг урд гүйцэтгэж байсан учир, хуучин үсэгзүйч, хэлзүйчнэр маань Банинийн хэлзүй, мөн түүнийг төвдийн үсэгзүйч, хэлзүйчнэр төвд хэлэндээ хэрхэн тохируулан зохицуулсаныг судлаж, сүүл сүүлдээ төвд үсэгзүйг их харгалздаг болсоны нэгэн заалт байнам. Чингээд, монгол хэлний ёс, үсэгзүйг тайлбарлахдаа тэр төвд загварыг харгалзан, санаа сэдэв авдаг байсан»¹² гэжээ. Ер нь зөвхөн манайханы биш бүх дэлхийн хэлшинжлэлийн онол нь м.э.ө IV зууны үед эртний энэтхэгийн том эрдэмтэн, дэлхийн ууган хэлшинжлэлч Баниний хэмээгч бээр урсам сайхан хэлээр шүлэглэж бичсэн "Санскрит бичгийн хэлний зүй" хэмээх бүтээл лүгээ холбоотой гэдэг нь нийтэд тодорхой юм. Тэр үеийн энэтхэгийн хэлшинжлэлийн онолын түвшний тухай Данийн нэрт эрдэмтэн агсан В. Томсен бичихдээ: "Высота, которую достигло языкознание у индусов, совершенно исключительна, и до этой высоты наука о языке в Европе не могла подняться вплоть до XIX в., да и то научившись многому у индийцев"¹³ хэмээн өндөр

үнэлсэн байгаа юм. Ийм өндөр түвшинд хүрсэн эртний энэтхэгийн хэлшинжлэлийн онол нь бурхан шашны дэлгэрэлтийг дагалдан хөрш зэргэлдээ орнуудад тархаж түгэхдээ эртнээс соёлын нягт харилцаатай байсан монгол орныг ч нөлөөлсөн ажээ. XIV зууны үеийн бүтээл болох "Зүрхэний тольт" -оос XVIII зууны "Огторгуйн маань" хүртэл эртний энэтхэгийн хэлшинжлэлийн арга, үзэл нь манай хэлзүйн бүтээлийг гүнзгий нөлөөлсөн нь илхэн бөгөөд, түүний нэгэн жишээг дурдабал, үсгүүдээ Хятадын ёсоор ба Энэтхэгийн ёсоор огторгуй, хий, гал, ус, шороо буюу модон, гал, шороо, төмөр, ус гэх мэт таван махбодод хувааж, ямар ямар үсгүүд аль аль махбодод харъяалагдах, тэдгээрийн үүсэх орон аль болох тэргүүтнийг тодорхойлон өгүүлэж, таван махбодоо дотор нь нөхөр, дайсан хэмээн хувааж, аль махбод нь аль махбодтойгоо нөхөр буюу дайсан болохыг ялган зааж, хэрвээ эцэг хүү хоёр, эр эм хоёр, багш шавь хоёр, ноён түшмэл хоёр сэлтийн нэрийн тэргүүн үсэг нь нөхөр махбод байвал шид бүтэх, дайсан махбод байвал хор болох, ядам бурханы тарни урихад, уригч хүний нэрийн тэргүүн үсэг хийгээд ядамын тарнийн тэргүүн үсэг хоёр хэрвээ дайсан байвал, гийгүүлэгч бөгөөс өвчин олон болох, эгшиг дайсан болвоос амин лугаа хагацах, саармаг болвоос муу юм бээр үгүй, нөхөр болвоос шид бүтмүй гэх мэтчлэн авиаг шидчлэн үзэдэг үзэлт мөн. Ингэж авиа бүхнийг шидтэй хэмээн үзэдэг үзэл нь эртний санскрит бичиг дээр үлдсэн ариун судрыг судлаж шинжлэхээс эхэлсэн хэлшинжлэлийнхний гол үзэл байсан бөгөөд, энэ тухай Н. А. Кондрашов бичихдээ: "Они были убеждены, что воспроизведение священных ведических гимнов только тогда выполняет свою религиозно-магическую функцию, когда осуществляется в фонетически безукоризненной форме» гэж заагаад, энэхүү үзэлийн хүргэсэн ач үрийн тухай: "это обстоятельство вызвало стремление к фонетической правильности и стало стимулом фонетических исследований" гэжээ¹⁴.

Эртний энэтхэгийн хэлшинжлэлийн онол нь Европт маш хожим, XVIII зууны сүүлчээр, хэзээ англичууд санскрит хэл лүгээ танилцсан тэр үеэс нөлөөлөх болсон байхад, манай өвөг дээдэс наад захдаа "Зүрхэний тольт" -ын үед энэтхэгийн хэлшинжлэлийн онол лугаа нэгэнтээ танил байсан бөгөөд, эртний энэтхэгийн хэлний тухай үзэл нь манай үсэг зүйч, хэл зүйч нарыг гүн нөлөөлж байсан учир манай хэлшинжлэлийн онолын түвшин ч их дээр үед дээд хэмжээнд хүрч чадсан ажээ.

Монгол, түвд, санскрит хэлнээ нэвтэрсэн, таван ухааны туйлд хүрч Бандид цолоор өргөмжлөгдсөн богд багш Заяа бандид Огторгуйн Далай филолог мөртлөө шашны зүтгэлтний хувьд яриангүй энэтхэгийн хэлний тухай үзэлийг сайн мэддэг байсан ба түүнд гүн нөлөөлөгдсөн гэдэг нь илхэн бөгөөд, мөн энэ нөлөөлөл нь нарийн боловсронгуй шинэ нэгэн үсэг бичгийн системийг зохион үйлдэж чадсаны гол нэгэн хүчин зүйл болсон хэмээн үзэж болох ажээ.

¹ Лувсанбалдан Х. Тод үсэг түүний дурсгалууд. 1975, УБ.; Санжеев Г. Д. Лингвистическое введение в изучение истории письменности монгольских народов, 1977, Улан-удэ; Шагдарсүрэн Ц. Монгол үсэг зүй, 1986, Бээжин.

² Амгалан М. Тод монголын дэлгэрэнгүй цагаан толгой байсан тухай мэдээ // *Studia Linguae et Litterarum*. Toms. IX, Fasc. 16. 187 – 188 тал.

³ H.Luvsanbaldan(Oulanbator). Deux Syllabaires Oirates. *Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae*, Tomus XXV, 1972. pp. 209-219

⁴ Баярсүрэн Ц. Об одном алфавите ясного письма // Монгольский лингвистический сборник, М. 1985. С. 146-149

⁵ Ринчэн Б. Монгол бичгийн хэлний зүй, Удиртгал. УБ., 1964. 108 тал.

⁶ Danjindayba. Jiruken-ü toltu-yin tayilburi oytoruyi-yin mani kemekü sudur orosibai // *Mongyol kele šinjilel-ün durasqal bičig. Kökeqota*, 1983.

⁷ Ayvangdandar. Mongyol üsüg-ün yosun-i sayitur nomlaysan kelen-ü čimeg kemegdekü orosibai // мөн тэнд.

⁸ Lobsančukubar. Mongyol üsüg-ün yool yosun-i tododqayči toli kemekü bičig // мөн тэнд.

⁹ Ринчэн Б. Монгол бичгийн хэлний зүй. Авиан зүй. УБ., 1964. 89 тал.

¹⁰ Кондрашов Н. А. История лингвистических учений. М., 1979. С. 9

¹¹ Владимирцов Б. Я. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, М., 1989. С. 89

¹² Ринчэн Б. Монгол бичгийн хэлний зүй. Авиан зүй. УБ., 97 – 98 тал.

¹³ Томсен В. История языковедения до конца XIX века. М., 1939. С. 10

¹⁴ Кондрашов Н.А. Указ. соч. С. 9